



БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2024 оны 09 сарын 02 өдөр

Дугаар А/142

Улаанбаатар хот

Хөрөнгө гаргах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Сууц өмчлөгчдийн холбооны эрх зүйн байдал, нийтийн зориулалттай орон сууцны байшингийн дундын өмчлөлийн эд хөрөнгийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.3 дахь заалт, Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалын хавсралтын 2.1.5 дахь заалт, Нийслэлийн Засаг даргын 2022 оны А/583 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.2024-2025 оны өвөлжилтийн бэлтгэл ажлыг хангах хүрээнд 2 дугаар хорооны орон сууцны 14 болон 16 дугаар байрны дээврийн ус зайлуулах хоолой засварлах ажлыг Их хангай Сууц өмчлөгчдийн холбоо (З.Нармандах)-д үүрэг болгосугай.

2.Засварын ажилд шаардагдах хөрөнгийн төсвийг хавсралтаар баталсугай.

3.Өвөлжилтийн бэлтгэл ажлыг хангахад шаардагдах 1,688,500 (Нэг сая зургаан зуун наян найман мянга таван зуу) төгрөгийг Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргахыг Засаг даргын Тамгын газрын Ерөнхий нягтлан бодогч (С.Баасанхүү)-д зөвшөөрсүгэй.

4.Тус ажлыг зохион байгуулж дууссанаас хойш 14 хоногийн дотор үр дүнг эргэн танилцуулахыг Тохижилт, худалдаа үйлчилгээний хэлтэс (Д.Хүрэлбаатар)-т, Санхүүгийн тайланг ирүүлэхийг Их хангай Сууц өмчлөгчдийн холбоо (З.Нармандах)-нд, захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж, ажиллахыг дүүргийн менежер (Г.Дагвадорж)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



А.СҮХБОЛД

Нийслэлийн Багахангай дүүргийн Засаг даргын  
2024 оны 09 сарын 02-ны өдрийн 11/4 дугаар  
захирамжийн хавсралт



2 ДУГААР ХОРООНЫ ОРОН СУУЦНЫ  
14, 16 ДУГААР БАЙРНЫ ДЭЭВРИЙН УС ЗАЙЛУУЛАХ ХООЛОЙ ЗАСВАРЛАХ  
АЖИЛД ШААРДАГДАХ ХӨРӨНГИЙН ТӨСӨВ

Д/д	Материалын нэр	Хэмжих нэгж	Тоо ширхэг	Нэгж үнэ	Бүгд үнэ
1	Дээврийн ус зайлуулах пласмастин турба ф100	м	8000	149	1,192,000
2	Ус тосох дөрвөлжин цорго	ш	8000	20	160,000
3	Булан ф90	ш	5500	17	93,500
4	Муфт ф100	ш	4500	32	144,000
5	Булан	ш	4500	22	99,000
Нийт үнэ:					<b>1,688,500</b>